



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/38

Бодь

┌
Сумын цэргийн бүртгэлийг явуулах
тухай
└

Монгол Улсын Батлан хамгаалахын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан журам, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/748 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 2022 оны цэргийн бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. Цэргийн бүртгэлийг явуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Цэргийн бүртгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Эрдэнэцэцэг), Хэсгийн төлөөлөгч (М.Цэнд-Аюуш) нарт даалгасугай.

4. Хүн амын шилжилт хөдөлгөөний мэдээллийн бүртгэлийг багийн Засаг дарга нартай хамтран 2021 оны жилийн эцсийн байдлаар гаргаж албажуулан, ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр ханган ажиллахыг багийн Засаг дарга нар, Улсын бүртгэгч (Б.Тунгалаг), Татварын Улсын байцаагч (Г.Оюунсүрэн) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

6. Сумын Засаг даргын 2022 оны А/02 дугаарын захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.


ДАРГА

Р.БАТЖАРГАЛ



642201059

Сумын Засаг даргын 2022 оны 04
дүгээр сарын 20 -ны өдрийн А/38 тоот
захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч Т.Эрдэнэцэцэг
(Засаг даргын Тамгын газрын даргын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд Ж.Лхагвасүрэн
(Уу-булан 1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Наранбаатар
(Хүйс 2 дугаар багийн Засаг дарга)
У.Батцэцэг
(Хөнөг 3 дугаар багийн Засаг дарга)
Б.Мөнхбат
(Цагаан-ус 4 дүгээр багийн Засаг дарга)
Б.Ганцэцэг
(Бодь 5 дугаар багийн Засаг дарга)
М.Цэнд-Аюуш
(Хэсгийн төлөөлөгч)
О.Баасанбат
(Нийгмийн даатгалын байцаагч)
Б.Тунгалаг
(Улсын бүртгэгч)
Ц.Мөнхнаран
(Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)
Ц.Цэрэнхүү
(Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга М.Бямбатогоо
(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

oOo